# БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Булган сумын 4-р цэцэрлэгийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2025/181/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2025 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

“Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын захирал:Д.Мягмарсүрэн
Утас: 99030170 Цахим хаяг: dalaivan.et@gmail.com

“Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын Аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 99921600 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт ..........................................................................
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .............................................
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.......................................................................
    3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ...............................................................
    3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ..............................................................
    3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .......................................................
    3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт ..........
4. Аудитын тайлан ...............................................................................................
   4.1 Ерөнхий зүйл ..............................................................................................
   4.2 Материаллаг байдал .....................................................................
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.........................................................
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ............................
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ................................................
5. Аудитын илрүүлэлт .......................................................................
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл ....................................................


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2025.02.24. № 260.

танай ________________ны № ________________т

БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН
4 ДҮГЭЭР ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ П.АРИУНАА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн Сайхан сумын цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайхан сумын цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Сайхан сумын цэцэрлэг нь 2024 онд 220 хүүхэдтэй үйл ажиллагаа явуулан гүйцэтгэлээр санхүүжсэн. Тайлант онд Боловсролын яамнаас 37,598.6 мянган төгрөгийн бараа материал, 152,831.6 мянган төгрөгийн үндсэн төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй авч санхүүгийн тайланд тусгасан байна.

**Аудитын гол асуудал**

Боловсролын байгууллага гүйцэтгэлд суурилсан төсвөөр санхүүжүүлэх болсноор сургуулийн өмнөх боловсрол олгох хөтөлбөрөөс хэрэгжүүлэх арга хэмжээ 7 болж зардлын зүйл анги багасаж, ихэнх зардал бараа үйлчилгээний бусад зардлаас зарцуулах болсон байна.

Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 128 тогтоолоор төрийн албан

032502498

хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосон байна. Мөн 2024 оны 9 сарын 1-нээс Боловсрол шинжлэх ухааны сайдын 2024 оны 02 сарын 26-ны өдрийн А/85, А/34 тоот тушаалаар "Орон тооны хязгаарын жишиг норматив" батлагдсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр нийт 4 зорилтын хүрээнд 42 арга хэмжээ хэрэгжүүлж ажиллан 92.6 хувьтай дүгнүүлсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ЭНХЦООДОЛ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **102,943,932.40** | **167,745,418.76** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 53,990,748.40 | 83,417,110.86 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 53,990,748.40 | 83,417,110.86 |
| **3121** | **Төгрөг** | 53,990,748.40 | 83,417,110.86 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 53,990,748.40 | 83,417,110.86 |
| **33** | **АВЛАГА** | - | 380,008.90 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 380,008.90 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 48,953,184.00 | 83,948,299.00 |
| **351** | **Түүхий эд материал** | - | 19,515,089.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | - | 19,515,089.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 48,953,184.00 | 64,433,210.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 164,200.00 | 422,600.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 149,800.00 | 5,415,900.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 6,212,500.00 | 5,660,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | - | 120,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 9,568,384.00 | 9,645,710.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 32,858,300.00 | 43,169,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **53,640,426.67** | **198,477,504.22** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 53,640,426.67 | 198,477,504.22 |
| **392** | **Биет хөрөнгө** | 19,952,926.67 | 165,127,504.22 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 38,100,636.00 | 139,887,101.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (24,323,602.81) | (36,439,072.49) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 15,899,040.00 | 72,539,973.30 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (9,723,146.52) | (12,197,475.37) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | - | 1,352,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | - | (15,022.22) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 33,687,500.00 | 33,350,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,350,000.00 | 1,350,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,012,500.00) | (1,350,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 33,350,000.00 | 33,350,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **156,584,359.07** | **366,222,922.98** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **156,584,359.07** | **366,222,922.98** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 156,584,359.07 | 366,222,922.98 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 76,649,075.00 | 76,649,075.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (9,082,276.30) | 200,545,287.60 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (9,082,276.30) | (9,082,276.30) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 209,627,563.90 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 89,017,560.37 | 89,017,560.37 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **156,584,359.07** | **366,222,922.98** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **566,720,300.00** | **1,123,077,487.30** |

| | | | |
|---|---|---|---|
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,461,800.00** | **194,637,687.30** |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 155,553,598.30 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 5,461,800.00 | 37,598,589.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | - | 1,485,500.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | - | 1,485,500.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **561,258,500.00** | **928,439,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 493,258,500.00 | 810,339,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 493,258,500.00 | 810,339,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 68,000,000.00 | 118,100,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 68,000,000.00 | 118,100,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **527,223,595.25** | **913,449,923.40** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **527,223,595.25** | **913,449,923.40** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 521,031,573.32 | 906,409,106.91 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 343,892,876.55 | 598,882,378.40 |
| 210101 | Үндсэн цалин | 223,741,691.97 | 396,922,486.00 |
| 210102 | Нэмэгдэл | 104,548,748.21 | 168,978,234.00 |
| 210104 | Урамшуулал | 15,602,436.37 | 32,981,658.40 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 43,094,050.04 | 74,397,430.24 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,538,917.50 | 50,504,317.54 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,488,460.03 | 5,991,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,781,527.42 | 2,996,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 662,889.84 | 2,996,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,622,255.25 | 11,909,212.70 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 62,491,078.07 | 94,259,183.51 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,456,252.03 | 7,141,393.35 |
| 210302 | Түлш, халаалт | 20,315,941.49 | 59,246,381.30 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,218,884.55 | 9,871,408.86 |
| 210304 | Байрны түрээс | 32,500,000.00 | 18,000,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,080,500.00 | 7,135,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 7,080,500.00 | 7,135,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 37,441,424.00 | 65,321,094.00 |
| 210502 | Хоол, хүнс | 37,441,424.00 | 65,321,094.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,000,000.00 | 16,800,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 16,800,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 566,000.00 | 494,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 566,000.00 | 494,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 23,465,644.66 | 49,120,020.76 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,709,270.00 | 20,405,299.98 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,661,150.00 | 13,897,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 9,095,224.66 | 14,828,987.45 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 6,192,021.93 | 7,040,816.49 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3,683,100.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,683,100.00 | - |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,508,921.93 | 7,040,816.49 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,508,921.93 | 7,040,816.49 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **39,496,704.75** | **209,627,563.90** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **39,496,704.75** | **209,627,563.90** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **561,258,500.00** | **928,439,800.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **561,258,500.00** | **928,439,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 493,258,500.00 | 810,339,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 493,258,500.00 | 810,339,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 68,000,000.00 | 118,100,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 68,000,000.00 | 118,100,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **508,625,746.59** | **896,574,637.54** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **508,625,746.59** | **896,574,637.54** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **502,433,724.66** | **889,533,821.05** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 343,892,876.55 | 599,187,800.00 |
| 210101 | Үндсэн цалин | 223,741,691.97 | 396,922,486.00 |
| 210102 | Нэмэгдэл | 104,548,748.21 | 168,978,234.00 |
| 210104 | Урамшуулал | 15,602,436.37 | 33,287,080.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 43,094,050.04 | 74,472,017.54 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,538,917.50 | 50,504,317.54 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,488,460.03 | 5,991,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,781,527.42 | 2,996,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 662,889.84 | 2,996,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,622,255.25 | 11,983,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 62,491,078.07 | 94,259,183.51 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,456,252.03 | 7,095,404.65 |
| 210302 | Түлш, халаалт | 20,315,941.49 | 59,263,096.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,218,884.55 | 9,900,682.86 |
| 210304 | Байрны түрээс | 32,500,000.00 | 18,000,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 38,304,600.00 | 65,292,920.00 |
| 210502 | Хоол, хүнс | 38,304,600.00 | 65,292,920.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,000,000.00 | 16,800,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 16,800,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 566,000.00 | 494,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 566,000.00 | 494,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11,085,120.00 | 39,027,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,385,220.00 | 32,982,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,699,900.00 | 6,045,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6,192,021.93** | **7,040,816.49** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3,683,100.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,683,100.00 | - |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,508,921.93 | 7,040,816.49 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,508,921.93 | 7,040,816.49 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **52,632,753.41** | **31,865,162.46** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **2,438,800.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **2,438,800.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 2,438,800.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 2,438,800.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(2,438,800.00)** |

| | | | |
|---|---|---|---|
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 52,632,753.41 | 29,426,362.46 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 53,990,748.40 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 53,990,748.40 | 83,417,110.86 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 76,649,075.00 | 89,017,560.37 | (9,082,276.30) | 156,584,359.07 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **76,649,075.00** | **89,017,560.37** | **(9,082,276.30)** | **156,584,359.07** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 229,021,330.78 | 229,021,330.78 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **76,649,075.00** | **89,017,560.37** | **219,939,054.48** | **385,605,689.85** |
| D01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **76,649,075.00** | **89,017,560.37** | **219,939,054.48** | **385,605,689.85** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **76,649,075.00** | **89,017,560.37** | | 165,666,635.37 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 209,627,563.90 | 209,638,563.91 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **76,649,075.00** | **89,017,560.37** | **200,545,287.60** | **366,211,922.97** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 975,476,183.51 | 891,972,621.05 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 975,476,183.51 | 889,533,821.05 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 975,476,183.51 | 889,533,821.05 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 674,468,800.00 | 599,187,800.00 |
| 210101 | Үндсэн цалин | 466,990,900.00 | 396,922,486.00 |
| 210102 | Нэмэгдэл | 184,560,500.00 | 168,978,234.00 |
| 210104 | Урамшуулал | 22,917,400.00 | 33,287,080.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 77,924,700.00 | 74,472,017.54 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 52,990,200.00 | 50,504,317.54 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,232,400.00 | 5,991,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,117,000.00 | 2,996,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,117,000.00 | 2,996,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,468,100.00 | 11,983,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 94,259,183.51 | 94,259,183.51 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,095,404.65 | 7,095,404.65 |
| 210302 | Түлш, халаалт | 59,263,096.00 | 59,263,096.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,900,682.86 | 9,900,682.86 |
| 210304 | Байрны түрээс | 18,000,000.00 | 18,000,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 67,588,200.00 | 65,292,920.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 67,588,200.00 | 65,292,920.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 16,800,000.00 | 16,800,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 16,800,000.00 | 16,800,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,425,800.00 | 494,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,425,800.00 | 494,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 42,009,500.00 | 39,027,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 35,456,600.00 | 32,982,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,552,900.00 | 6,045,900.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **2,438,800.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 2,438,800.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 2,438,800.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 982,430,500.00 | 928,439,800.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 864,330,500.00 | 810,339,800.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 864,330,500.00 | 810,339,800.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 118,100,000.00 | 118,100,000.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 118,100,000.00 | 118,100,000.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **53,990,748.40** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **83,417,110.86** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 21.00 | 21.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 12.00 | 12.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 8.00 | 8.00 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 150.00 | 150.00 |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | 150.00 | 150.00 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 150.00 | 150.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **21.00** | **21.00** |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 11.00 | 11.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 10.00 | 10.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 81,520.0 мянган төгрөгийн 1 алдаа[1] зөрчил[2] илэрснээс, 1,234.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 185.7 мянган төгрөгийн төлбөрийн акт, 70,100.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 10,000.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Аудитаар залруулсан зөрчилтэй асуудлаас 2,846.0 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь тогтоосон материаллаг байдлын дүнгээс бага байгаа тул өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн болно.

**Залруулсан алдаа:**

- Ажил хавсран гүйцэтгэж буй ажилтны цалинг тооцоолохдоо хавсран ажиллаж буй албан тушаалын цалингаар бус өөрийн үндсэн ажлын цалингаар тооцон 305.4 мянган төгрөг илүү олгосон байна. Энэ нь

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Хөдөлмөрийн тухай хуулийн 56.1.Ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно. 56.2."Энэ хуулийн 56.1-д заасны дагуу ажиллах ажилтанд гүйцэтгэх ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг нэмж олгоно".гэсэн заалтыг зөрчсөн байна.

- Тайлангийн хугацаанд эцэг эх, асран хамгаалагчаас авч хэрэглэдэг сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийн бүртгэл хангалтгүй тулган шалгахад анхан шатны баримт дутуу, эцсийн үлдэгдэл таарахгүй 928.9 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнагдсан байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, Боловсролын ерөнхий газрын даргын 2023 оны 1/4511 тушаалын хавсралтын улирал бүр тайлагнах гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**3.1Төлбөрийн акт**

*Илрүүлэлт:*Хоолны өдөрлөгөөр гарсан хүнсний материал тухайн өдрийн хоолны менюд байхгүй, багшийн ирцээс хоолны өдөрлөгийн ирц илүү зэргээр нийт 185.7 мянган төгрөгийн материал илүү зарлагадсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Засгийн газрын 2024 оны "Хоолны зардлын норматив батлах тухай" 237 дугаар тогтоол-ыг зөрчсөн байна.

**3.2 Албан шаардлага**

*Илрүүлэлт:*Цалингийн тооцоололд сорил гүйцэтгэхэд 3 ажилтны нийгмийн даатгалын ажил мэргэжлийн кодыг буруу тооцож 1,426.9 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл дутуу тооцогдсон байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 102.1.5.цалин хөлсийг тооцох аргачлал ил тод, ойлгомжтой байх ба Сангийн сайд, ХНХС-ын 2024 оны А/44/А/40 дугаар тушаалын "Ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд бүртгэх даатгуулагчийн төрлийн код" гэсэн хавсралтыг зөрчсөн байна.

*Илрүүлэлт:*Үнэ төлбөргүй хүлээн авсан мянган төгрөгийн 52,584.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 16,089.1 бараа материалын орлогод авсан тушаал болон тооллого комиссын тушаал, эмчийн үзлэгт хамрагдсан үзлэгийн тушаалыг шилэн дансанд байршуулж мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.4.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **<u>Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудал.</u>**

*<u>Илрүүлэлт</u>:* Цэцэрлэгт хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүднээс “гараас гарт” зарчмыг баримтлан хүүхдийг өглөө багшид нь, ажлын дараа эцэг эх, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгдөг бүртгэл хангалтгүй байна.Энэ нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/239 тушаалаар батлагдсан "Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүчирхийлэл өртөхөөс урьдчилан сэргийлэх журам"-ын 3.5.3.“Бага насны хүүхдийг заавал эцэг эх, асран хамгаалагчаас хүлээн авах, хүлээлгэн өгөх /гараас гарт/ журам” боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллана.гэсэн заалтыг хангалттай хэрэгжүүлж ажиллаагүй байна.

<u>Өгсөн зөвлөмж</u>: Цаашид холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллах.

**<u>2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал</u>**

*<u>Илрүүлэлт</u>:* Бараа материалын дансанд 1,600.0 мянган төгрөгийн шовгор байшин бүртгэлтэй байна. Шовгорт зарцуулсан 10.000.0 мянган төгрөгийн засварын материалыг зардлаар тусган зарлагдсан байна. Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгө гэдэг нь дараах шинжтэй биет зүйлсийг хэлнэ. Үүнд: "Бараа, үйлчилгээний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэнд ашиглах, бусдад түрээслэх эсвэл удирдлагын хэрэгцээнд ашиглах зорилгоор эзэмшиж байгаа; ба Нэгээс дээш тайлант үед ашиглагдахаар хүлээгдэж буй" зэрэг зөрчигдсөн байна.

<u>Өгсөн зөвлөмж</u>: Цаашид холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Ажил хавсран гүйцэтгэж буй ажилтны цалинг тооцоолохдоо хавсран ажиллаж буй албан тушаалын цалингаар бус өөрийн үндсэн ажлын цалингаар тооцон 305.4 мянган төгрөг илүү олгосон байна. | 1 | 305.4 | | | 1 | 305.4 | 1 | 305.4 | | | | |
| Тайлангийн хугацаанд эцэг эх, асран хамгаалагчаас авч хэрэглэдэг сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийн 928.9 мянган төгрөгийн материал дутуу орлогод бүртгээгүй байна. | 1 | 928.9 | 1 | 928.9 | | | 1 | 928.9 | | | | |
| **Дүн** | **2** | **1,234.3** | **1** | **928.9** | **1** | **305.4** | **2** | **1,234.3** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Хоолны өдөрлөгөөр гарсан хүнсний материал тухайн өдрийн хоолны менюд байхгүй, багшийн ирцээс хоолны өдөрлөгийн ирц илүү зэргээр нийт 185.7 мянган төгрөгийн материал илүү зарлагадсан | 1 | 185.7 | 1 | 185.7 | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| байна. | | | | | | | | | | | | |
| “гараас гарт” зарчмыг баримтлан хүүхдийг өглөө багшид нь, ажлын дараа эцэг эх, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгдөг бүртгэл хангалтгүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Бараа материалын дансанд 1,600.0 мянган төгрөгийн шовгор байшин бүртгэлтэй байна. Шовгорт зарцуулсан 10.000.0 мянган төгрөгийн засварын материалыг зардлаар тусган зарлагдсан байна. | 1 | 10,000.0 | | | | | 1 | 10,000.0 | | | | |
| Хүнсний материал худалдан авах ажиллагааны тендерийн материал шаардлага хангахгүй | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Цалингийн тооцоололд сорил гүйцэтгэхэд 3 ажилтны нийгмийн даатгалын ажил мэргэжлийн кодыг буруу тооцож 1.426.9 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл дутуу тооцогдсон байна. | 1 | 1,426.8 | | | 1 | 1,426.8 | | | | | | |
| **Дүн** | **5** | **11,612.5** | **1** | **185.7** | **1** | **1,426.8** | **3** | **10,000.0** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан мянган төгрөгийн 52.584.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 16.089.1 бараа материалын орлогод авсан тушаалыг шилэн дансанд байршуулж мэдээлээгүй байна. | 1 | 68,674.0 | | | 1 | 68,674.0 | | |
| **Дүн** | **1** | **68,674.0** | **-** | **-** | **1** | **68,674.0** | | **-** |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | НИЙТ | 1 | 1 | | | 1 | | | |